



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж
хувь бодох аргачлал батлах тухай


Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар батлагдсан “Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам”-ын 4 дүгээр хэсгийн 4.6.5 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Боловсролын үнэлгээний төвийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ш.Шижир-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАН-ЭРДЭНЭ



СУРАЛЦАГЧИЙН СУРЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУВЬ БОДОХ АРГАЧЛАЛ

1. Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодоход сургалтын төлөвлөгөөний дагуу судалж, үнэлэгдсэн хичээл бүрээр авсан үнэлгээ /хувь/-г тухайн хичээлийг 7 хоногт судалсан цагаар үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг 7 хоногт судалсан цагийн нийлбэрт хувааж /арифметикийн жинлэсэн дундаж/, аравны орны нарийвчлалтай бодож гаргана.

$$\text{Сурлагын үнэлгээний дундаж хувь} = \frac{a_1 * S_1 + a_2 * S_2 + \dots + a_n * S_n}{S_1 + S_2 + \dots + S_n}$$

n- хичээлийн тоо

$a_1, a_2 \dots a_n$ – сургалтын төлөвлөгөөний дагуу судалж үнэлэгдсэн заавал болон сонгон судалсан, төрөлжсөн эсхүл гүнзгийрүүлэн судалсан хичээлийн үнэлгээ /хувь/

$S_1, S_2 \dots S_n$ – сургалтын төлөвлөгөөний дагуу тухайн хичээлийг 7 хоногт судалсан цаг

2. Сурлагын үнэлгээний дундаж хувийг тооцоход анги дэвших болон улсын шалгалтын үнэлгээ хамаарахгүй.

3. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчдөд олгох боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх/-т бичигдэх сурлагын үнэлгээний дундаж хувийг боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэгдсэн суралцагчийн үнэлгээний мэдээлэлд үндэслэн тооцно.

4. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчийн сурлагын үнэлгээний дундаж хувь тооцоход тухайн түвшинд судалсан хичээлийн сүүлийн ангийн сурлагын үнэлгээ, 7 хоногт судалсан цагийн өгөгдлийг ашиглана.